

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: САГ-2026/97/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: В.Эрдэнэцогт Утас:260512 Цахим хаяг: erdenetsogt.v@audit.gov.mn Аудитор: Б.Отгонцэцэг Утас:261628 Цахим хаяг: otgontsetsegb@audit.gov.mn Их Наяд Аудит ХХК-ын захирал: Х.Ариунзул Утас: 99077062 Цахим хаяг: ikhnyadaudit@gmail.com
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	15
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	15
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17
4. АУДИТЫН ТАЙЛАН	22
4.1 Ерөнхий зүйл.....	22
4.2 Материаллаг байдал	22
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	22
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	22
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	23
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	24
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	25
5.1 Төлбөрийн акт	25
5.2 Албан шаардлага.....	26
5.3 Зөвлөмж	26
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	28

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АТӨЯХАТ	Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар
НӨХГ	Нийслэлийн өмчийн харилцааны газар
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХӨСҮТ	Халдварт өвчин судлалын үндэсний төв
ЭМЯ	Эрүүл мэндийн яам



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/347

танай _____-ны № _____-г

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Тухайлбал:

- Түлш, шатах тослох материалыг замын хуудсыг үндэслэн жолоочийн тооцоо бодоогүй, шатахууны зарцуулалтанд бүртгэлээр тавих хяналт хангалтгүй 81,493.1 мянган төгрөгийн зарцуулалт хийсэн;
- Эрүүл мэндийн яаманд гэрээтээр давхар ажилладаг тус төвийн үндсэн ажилтан жолооч нь сар бүр цалингаа бүтэн авч байсан бөгөөд жолооч нь үндсэн ажлаа бүрэн хийсэн эсэх нь цагийн бүртгэл болон жолоочийн замын хуудсаар нотлогдохгүй байхад 31,449.9 мянган төгрөгийн цалинг төсвөөс олгосон зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай 5 дугаар зүйлийн 5.1, 5.1.5, 13 дугаар зүйлийн 13.1,13.7, 20 дугаар зүйлийн 20.1.4, 20.2.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 84 дүгээр зүйл 84.1-д заасан заалтуудтай нийцээгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Зоонозын өвчин судлалын үндэсний төв нь “Цар тахлаас сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх монгол улсын чадавхыг нэг эрүүл мэнд зарчимд тулгуурлан бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд 10 чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлж, 7 төрлийн 66 лабораторийн тоног төхөөрөмжийг захиалж, лабораторийн засварт 152,709.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 1/2160 дугаар тогтоолоор 1,581,829.3 мянган төгрөгийн үлдэх өртөггүй үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, балансын үнийг 474,548.8 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосны дагуу үндсэн хөрөнгийг нэр төрлөөр нь бүртгэлд тусгаж тайлагнасан байна.

Бусад асуудал

Тус төвийн Био үйлдвэрлэлийн лаборатори нь 2025 онд нянгийн гаралтай халдварт өвчний оношилгоонд ашиглагдах тэжээлт орчин, биобэлдмэл, урвалж уусмалын технологийг үйлдвэрлэлд бүрэн нэвтрүүлснээр тайлант онд нийт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний 25.4 хувийг шинэ технологиор үйлдвэрлэж 14 аймгийн салбар төвүүдэд нийлүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	6,311,773,298.11	5,940,518,007.04
33	АВЛАГА	-	10,527,956.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	10,527,956.00
35	БАРАА МАТЕРИАЛ	6,311,773,298.11	5,929,990,051.04
35100	Түүхий эд материал	5,792,325,584.77	5,381,826,130.35
35110	Тусгайзориулалттайматериал	3,680,415,534.15	3,536,628,999.47
35130	Эмбоохматериал	2,111,910,050.62	1,845,197,130.88
35400	Дуусаагүй үйлдвэрлэл	519,447,713.34	548,163,920.69
35410	Бичиг хэргийн материал	11,423,810.00	39,712,125.00
35420	Аж ахуйн материал	310,408,246.30	265,350,884.30
35430	Сэлбэг хэрэгсэл	42,910,541.00	41,696,741.00
35440	Түлш, шатах тослох материал	5,822,212.28	7,288,784.63
35450	Барилгын засварын материал	30,793,250.00	28,739,400.00
35460	Хүнсний материал	115,194,272.00	129,562,272.00
35470	Бусад хангамжийн материал	2,895,381.76	35,813,713.76
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	13,069,135,841.68	12,489,365,180.03
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	13,069,135,841.68	12,489,365,180.03
39200	Биет хөрөнгө	12,311,614,841.68	11,709,082,513.36
39201	Барилга, байгууламж	9,549,419,569.70	9,549,419,569.70
39202	Хуримтлагдсан элэгдэл	1,005,285,820.30	1,210,048,928.70
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,847,843,580.80	1,847,843,580.80
39204	Хуримтлагдсан элэгдэл	918,665,914.88	1,088,714,843.64
39205	Машин, тоногтөхөөрөмж	6,325,852,812.64	5,082,035,771.10
39206	Хуримтлагдсан элэгдэл	3,747,420,032.80	2,834,478,027.57
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	530,262,220.31	511,538,142.30
39208	Хуримтлагдсан элэгдэл	270,391,573.79	148,512,750.63
39214	Бусадүндсэн хөрөнгө	446,551.77	-
39215	Хуримтлагдсан элэгдэл	446,551.77	-
39300	Биет бус хөрөнгө	757,521,000.00	780,282,666.67
39301	Программ хангамж	34,514,639.25	55,215,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	26,718,389.25	24,657,083.33
39303	Бусад	749,724,750.00	749,724,750.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	19,380,909,139.79	18,429,883,187.07
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	-	2,308,400.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	-	2,308,400.00
41300	Өглөг	-	2,308,400.00
41360	Бусад өглөг	-	2,308,400.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	2,308,400.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	19,380,909,139.79	18,427,574,787.07
51	Засгийн газрын хувь оролцоо	2,698,660,655.49	2,698,660,655.49
51200	Хуримтлагдсан үр дүн	13,448,540,557.11	12,495,206,204.39
51210	Өмнөх үеийн үр дүн	17,238,177,011.39	13,448,540,557.11
51220	Тайлант үеийн үр дүн	(3,789,636,454.28)	(953,334,352.42)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,233,707,927.19	3,233,707,927.19
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	19,380,909,139.79	18,429,883,187.07

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	ҮЗҮҮЛЭЛТ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	12,428,829,849.81	8,784,379,594.08
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,034,823,692.31	8,784,379,594.08
120	Нийтлэг татварын бус орлого	-	2,371,517,925.08
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	35,159,656.30
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	35,159,656.30
120009	Бусад орлого	-	336,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	525,197,094.67	772,911,841.94
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	6,481,750,834.37	1,563,110,426.84
122	Тусламжийн орлого	-	6,412,861,669.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	6,412,861,669.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	5,040,637,500.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	5,040,637,500.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,372,224,169.00
122131	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	1,290,629,019.00
122133	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	45,948,062.50
122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	35,647,087.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,394,006,157.50	-
1310	Улсын төсвөөс	5,394,006,157.50	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,802,103,635.00	-
1311	Нэмэлт санхүүжилт	591,902,522.50	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	440,816,777.50	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,075,500.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,634,245.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	119,376,000.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	8,246,183,588.57	8,600,563,956.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,246,183,588.57	8,600,563,956.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,727,341,966.81	8,307,898,114.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,028,581,376.14	3,576,673,642.45
210101	Үндсэн цалин	1,672,340,987.82	1,786,371,407.41
210102	Нэмэгдэл	1,013,816,908.32	1,164,898,202.67
210103	Унаа хоолны хөнгөлөлт	121,654,000.00	289,140,675.27
210104	Урамшуулал	220,769,480.00	336,263,357.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	400,192,895.03	464,580,885.23
210201	Тэтгэврийн даатгалын зардал	261,000,038.94	320,506,452.19
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	29,891,874.03	35,832,123.73
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	40,219,541.01	30,292,326.23

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	13,424,137.58	16,173,376.05
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	55,657,303.47	61,776,607.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	143,646,453.71	167,850,610.87
210301	Гэрэл цахилгааны зардал	63,879,275.20	75,674,028.15
210302	Түлш, халаалтын зардал	52,208,263.51	44,987,952.07
210303	Цэвэр, бохир усны зардал	18,438,915.00	12,608,630.65
210304	Байрны түрээс	9,120,000.00	34,580,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	712,879,648.46	165,718,835.00
210401	Бичиг хэрэг	29,962,070.46	21,510,725.00
210402	Тээвэр, шатахуун	109,025,657.00	114,417,964.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,817,290.00	6,792,416.00
210404	Ном, хэвлэл	-	1,199,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	16,040,631.00	6,782,020.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	1,095,200.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,320,000.00	13,921,510.00
210408	Бараа материал ақталсны зардал	543,714,000.00	-
2105	Нормативт зардал	863,784,797.35	1,510,753,010.48
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	835,560,351.85	1,368,821,197.98
210502	Хоол, хүнс	27,111,437.50	141,931,812.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,113,008.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	57,836,887.00	81,115,550.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,039,600.00	8,313,940.00
210604	Урсгал засвар	55,797,287.00	72,801,610.00
2107	Томилолт, зочны зардал	190,825,000.00	377,612,766.00
210702	Дотоод албан томилолт	190,825,000.00	377,612,766.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,648,808.17	53,935,207.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	195,872.17	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	5,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,488,375.00	1,433,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,506,920.00	1,344,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	363,000.00	363,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,414,100.00	14,363,366.00
210807	Газрын төлбөр	6,265,941.00	6,388,681.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	414,600.00	25,041,960.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,308,946,100.95	1,909,657,607.59
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	159,290,709.26	459,458,104.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	30,900,000.00	49,022,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,118,755,391.69	1,401,177,303.59
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	518,841,621.76	292,665,841.70
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	181,801,969.70
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	181,801,969.70
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	181,801,969.70
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	181,448,967.37
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал	-	353,002.33
2132	Бусад урсгал шилжүүлэг	211,739,634.73	110,863,872.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	204,185,634.73	110,513,872.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,554,000.00	350,000.00

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	307,101,987.03	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	304,822,955.30	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,279,031.73	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	4,182,646,261.24	183,815,637.76
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	15,000.00	-
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	15,000.00	-
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	7,972,297,715.52	1,137,149,990.18
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	15,354,166.71	-
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	7,956,943,548.81	1,137,149,990.18
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(7,972,282,715.52)	(1,137,149,990.18)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	(3,789,636,454.28)	(953,334,352.42)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	5,421,896,920.77	6,448,021,325.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	27,890,763.27	6,448,021,325.30
120	Нийтлэг татварын бус орлого	27,890,763.27	35,159,656.30
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	27,890,763.27	35,159,656.30
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	27,890,763.27	35,159,656.30
122	Тусламжийн орлого	-	6,412,861,669.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	6,412,861,669.00
12211	Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	5,040,637,500.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	5,040,637,500.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,372,224,169.00
122131	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	1,290,629,019.00
122132	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	-	45,948,062.50
122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	35,647,087.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,394,006,157.50	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,802,103,635.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,802,103,635.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	591,902,522.50	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	440,816,777.50	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,075,500.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,634,245.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	119,376,000.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,418,888,020.77	6,399,526,525.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,418,888,020.77	6,399,526,525.30

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,900,046,399.01	6,096,332,727.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,031,641,992.39	3,576,673,642.45
210101	Үндсэн цалин	1,638,876,449.61	1,786,371,407.41
210102	Нэмэгдэл	1,051,490,349.08	1,164,898,202.67
210103	Унаа хоолны хөнгөлөлт	121,946,506.49	289,140,675.27
210104	Урамшуулал	219,328,687.21	336,263,357.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	397,132,278.78	464,580,885.23
210201	Тэтгэврийн даатгалын зардал	274,631,559.23	320,506,452.19
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	31,424,158.26	35,832,123.73
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	19,505,404.61	30,292,326.23
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	14,991,291.00	16,173,376.05
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	56,579,865.68	61,776,607.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	143,646,453.71	167,850,610.87
210301	Гэрэл цахилгааны зардал	63,879,275.20	75,674,028.15
210302	Түлш, халаалтын зардал	52,208,263.51	44,987,952.07
210303	Цэвэр, бохир усны зардал	18,438,915.00	12,608,630.65
210304	Байрны түрээс	9,120,000.00	34,580,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	123,248,005.00	151,157,955.00
210401	Бичиг хэрэг	7,763,200.00	19,379,400.00
210402	Тээвэр, шатахуун	104,051,515.00	115,425,439.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,337,290.00	6,792,416.00
210404	Ном, хэвлэл	-	1,199,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,096,000.00	5,396,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	2,964,900.00
2105	Нормативт зардал	740,521,351.70	689,120,216.75
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	686,362,414.20	532,820,404.25
210502	Хоол, хүнс	40,065,937.50	141,931,812.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	14,093,000.00	14,368,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	44,956,100.00	79,145,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	2,155,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,039,600.00	7,456,040.00
210604	Урсгал засвар	42,916,500.00	69,533,960.00
2107	Томилолт, зочны зардал	190,825,000.00	377,612,766.00
210702	Дотоод албан томилолт	190,825,000.00	377,612,766.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,404,508.17	81,710,447.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	195,872.17	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	2,691,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,488,375.00	1,433,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,506,920.00	1,344,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	363,000.00	363,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,414,100.00	14,834,966.00
210807	Газрын төлбөр	6,265,941.00	6,388,681.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,170,300.00	54,654,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	206,670,709.26	508,480,304.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	175,770,709.26	459,458,104.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	30,900,000.00	49,022,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	518,841,621.76	303,193,798.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	192,329,926.00
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	192,329,926.00

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	192,329,926.00
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	181,448,967.37
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал	-	353,002.33
2131125	Төсвийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	10,527,956.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	211,739,634.73	110,863,872.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	204,185,634.73	110,513,872.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,554,000.00	350,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	307,101,987.03	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	304,822,955.30	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,279,031.73	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	3,008,900.00	48,494,800.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	3,008,900.00	48,494,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,008,900.00	48,494,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,008,900.00	48,494,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,008,900.00	48,494,800.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(3,008,900.00)	(48,494,800.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,698,660,655.49	3,233,707,927.19	17,238,177,011.39	23,170,545,594.07
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,698,660,655.49	3,233,707,927.19	17,238,177,011.39	23,170,545,594.07
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(3,789,636,454.28)	(3,789,636,454.28)
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,698,660,655.49	3,233,707,927.19	13,448,540,557.11	19,380,909,139.79
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,698,660,655.49	3,233,707,927.19	13,448,540,557.11	19,380,909,139.79
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(953,334,352.72)	(953,334,352.72)
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,698,660,655.49	3,233,707,927.19	12,495,206,204.39	18,427,574,787.07

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	5,066,030,700.00	4,894,348,188.93	171,682,511.07	96.6
12	Татварын бус орлого	5,066,030,700.00	4,894,348,188.93	171,682,511.07	96.6
120	Нийтлэг татварын бус орлого	24,631,700.00	35,159,656.30	(10,527,956.30)	142.7
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	24,631,700.00	35,159,656.30	(10,527,956.30)	142.7
122	Тусламжийн орлого	5,041,399,000.00	4,859,188,532.63	182,210,467.37	96.4
122005	Төсвөөс санхүүжих	5,041,399,000.00	4,859,188,532.63	182,210,467.37	96.4
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,066,030,700.00	4,883,820,232.63	182,210,467.37	96.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,066,030,700.00	4,883,820,232.63	182,210,467.37	96.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,954,030,100.00	4,772,956,360.63	181,073,739.37	96.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,555,764,900.00	3,429,157,993.86	126,606,906.14	96.4
210101	Үндсэн цалин	1,752,797,200.00	1,754,692,448.32	(1,895,248.32)	100.1
210102	Нэмэгдэл	1,211,772,900.00	1,049,061,513.17	162,711,386.83	86.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	369,381,400.00	289,140,675.27	80,240,724.73	78.3
210104	Урамшуулал	221,813,400.00	336,263,357.10	(114,449,957.10)	151.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	458,218,100.00	445,883,519.65	12,334,580.35	97.3
210201	Тэтгэврийн даатгал	289,438,000.00	301,809,086.61	(12,371,086.61)	104.3
210202	Тэтгэмжийн даатгал	32,746,100.00	35,832,123.73	(3,086,023.73)	109.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	54,641,700.00	30,292,326.23	24,349,373.77	55.4
210204	Ажилгүйдлийн даатгал	16,331,600.00	16,173,376.05	158,223.95	99.0
210205	Эрүүл мэндийн даатгал	65,060,700.00	61,776,607.03	3,284,092.97	95.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	142,804,400.00	133,270,610.87	9,533,789.13	93.3
210301	Гэрэл, цахилгаан	88,735,700.00	75,674,028.15	13,061,671.85	85.3
210302	Түлш, халаалт	41,371,500.00	44,987,952.07	(3,616,452.07)	108.7
210303	Цэвэр, бохир ус	12,697,200.00	12,608,630.65	88,569.35	99.3
2104	Хангамж, бараа материалын зардал	65,893,600.00	65,892,905.00	695.00	100.0
210401	Бичиг хэрэг	2,195,700.00	1,906,500.00	289,200.00	86.8
210402	Тээвэр, шатахуун	52,854,300.00	48,832,289.00	4,022,011.00	92.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,167,000.00	6,792,416.00	(2,625,416.00)	163.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,576,600.00	5,396,800.00	(820,200.00)	117.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,100,000.00	2,964,900.00	(864,900.00)	141.2
2105	Нормативт зардал	536,804,500.00	515,925,424.25	20,879,075.75	96.1
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	524,152,100.00	503,357,424.25	20,794,675.75	96.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,652,400.00	12,568,000.00	84,400.00	99.3

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	70,304,000.00	70,254,400.00	49,600.00	99.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,545,000.00	4,071,900.00	(526,900.00)	114.9
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	21,751,600.00	7,456,040.00	14,295,560.00	34.3
210604	Урсгал засвар	45,007,400.00	58,726,460.00	(13,719,060.00)	130.5
2107	Томилолт, зочны зардал	58,291,300.00	47,087,400.00	11,203,900.00	80.8
210702	Дотоод албан томилолт	58,291,300.00	47,087,400.00	11,203,900.00	80.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	56,569,400.00	56,256,447.00	312,953.00	99.4
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,691,600.00	2,691,600.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	1,433,400.00	1,433,400.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,379,100.00	1,344,800.00	34,300.00	97.5
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	423,800.00	363,000.00	60,800.00	85.7
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	43,114,800.00	43,034,966.00	79,834.00	99.8
210807	Газрын төлбөр	6,389,700.00	6,388,681.00	1,019.00	100.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	86,100.00	-	86,100.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,050,900.00	1,000,000.00	50,900.00	95.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,379,900.00	9,227,660.00	152,240.00	98.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,407,700.00	7,255,460.00	152,240.00	97.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,972,200.00	1,972,200.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	112,000,600.00	110,863,872.00	1,136,728.00	99.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	112,000,600.00	110,863,872.00	1,136,728.00	99.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	111,650,600.00	110,513,872.00	1,136,728.00	99.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	350,000.00	350,000.00	-	100.0
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	10,527,956.30	(10,527,956.30)	-
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	(10,527,956.30)	10,527,956.30	-
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	(10,527,956.30)	10,527,956.30	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	199.00	187.00	12.00	94.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	100.00	91.00	9.00	91.0
620001	Удирдах ажилтан	3.00	3.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	83.00	75.00	8.00	90.4
620003	Үйлчлэх ажилтан	14.00	13.00	1.00	92.9
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	94.00	91.00	3.00	96.8

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	61.00	58.00	3.00	95.1
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	33.00	33.00	-	100.0
66	НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ	4.00	4.00	-	100.0
660001	Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	4.00	4.00	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	-	1,372,224,169.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	1,372,224,169.0
122	Тусламжийн орлого	-	1,372,224,169.0
1221	Хандив тусламж /дотоод/	-	1,372,224,169.0
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,372,224,169.0
350011	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	1,290,629,019.0
350012	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	-	45,948,062.5
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	35,647,087.5
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	1,371,871,166.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	1,371,871,166.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	1,371,871,166.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	147,515,648.6
210101	Үндсэн цалин	-	31,678,959.1
210102	Нэмэгдэл	-	115,836,689.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	18,697,365.6
210201	Тэтгэврийн даатгал	-	18,697,365.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	34,580,000.0
210304	Байрны түрээс	-	34,580,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	-	85,265,050.0
210401	Бичиг хэрэг	-	17,472,900.0
210402	Тээвэр, шатахуун	-	66,593,150.0
210404	Ном, хэвлэл	-	1,199,000.0
2105	Нормативт зардал	-	173,194,792.5
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	29,462,980.0
210502	Хоол, хүнс	-	141,931,812.5
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,800,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	29,186,300.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	18,378,800.0
210604	Урсгал засвар	-	10,807,500.0
2107	Томилолт, зочны зардал	-	330,525,366.0
210702	Дотоод албан томилолт	-	330,525,366.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	53,654,000.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	53,654,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	499,252,644.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	452,202,644.0

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	47,050,000.0
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	353,002.3
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	(353,002.3)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	(353,002.3)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Зоонозын өвчин судлалын үндэсний төв нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Зоонозын халдварт өвчнийг тандах, хянах, эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээг судалгаа, нотолгоонд тулгуурлан мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулж, халдварыг эрсдэлийг багасгах замаар хүн амын өвчлөл эндэгдлийг бууруулах”-д оршино гэж тодорхойлсон байна.

Тус төв нь Монгол Улсын хэмжээнд зоонозын халдварт өвчнүүдийг тандах, хянах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хүн амын дунд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг оновчтой зохион байгуулах, зоонозын өвчний тархалтын тандалт судалгааг хийх, хүн амыг халдварт өртөх эрсдэлээс сэргийлэх, орон нутгийн харьяа байгууллагууд болон бусад эрүүл мэндийн байгууллагуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, лабораторийн лавлагаа тусламж, үйлчилгээ үзүүлэх, зоонозын халдварт өвчний мэдээллийн санг бүрдүүлэхэд мэргэжил арга зүйн удирдлагаар хангах чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв нь үйл ажиллагаандаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулиуд болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Төсвийн тухай хууль;
- Сангийн сайдын А/З дугаар тушаалаар “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг шинэчлэн баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/02-01 тоот тушаалаар шинэчлэн батлагдсан бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 951,026.0 мянган төгрөгөөр букуу 4.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	-	10,528.0	10,528.0
Бараа материал	6,311,773.3	5,929,990.1	(381,783.2)
Үндсэн хөрөнгө	13,069,135.8	12,489,365.2	(579,770.6)
Нийт хөрөнгө	19,380,909.1	18,429,883.2	(951,026.0)
Өр төлбөр	-	2,308.4	2,308.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	19,380,909.1	18,427,574.8	(953,334.4)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	19,380,909.1	18,429,883.2	(951,026.0)

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

Авлага дансны үлдэгдэл 10,528.0 мянган төгрөг болж өсөхөд үндсэн бус үйл ажиллагааны давсан орлого 10,528.0 мянган төгрөгийг Сангийн яамнаас авах татаас санхүүжилтийн авлагаар бүртгэснээр нэмэгдсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 5,929,990.1 мянган төгрөгт хүрч өмнөх оноос 381,783.2 мянган төгрөгөөр буурахад худалдан авсан 784,737.8 мянган төгрөг, ЭМЯ-ны ТНБД-ын А/58 дугаар тушаалаар эрүүл мэндийн салбарын нөөцийн агуулахад эм, эмнэлгийн хэрэгсэл, материал тоног төхөөрөмж шилжүүлэн өгсөн 993,363.5 мянган төгрөг, ХӨСҮТ-өөс болон бусад төсөвт байгууллагаас үнэ төлбөргүй өгсөн 569,746.9 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, ЭМЯ-аас өгсөн чиглэлийн дагуу эрүүл мэндийн бусад байгууллагуудад үнэ төлбөргүй шилжүүлсэн тусгай зориулалтын материал 1,137,150.0 мянган төгрөг, эм, эмнэлгийн хэрэгсэлд 1,368,769.2 мянган төгрөг, бичиг хэрэгт 49,073.6 мянган төгрөг, аж ахуйн материалд 17,998.4 мянган төгрөг, сэлбэг хэрэгсэлд 12,315.1 мянган төгрөг, шатах тослох материалд 81,493.1 мянган төгрөг, барилгын урсгал засварын материалд 18,363.6 мянган төгрөг, бусад аж ахуйн 44,468.5 мянган төгрөгийн бараа материал тус тус шилжүүлснээр хасагдсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 12,489,365.2 мянган төгрөг болж өмнөх оноос 579,770.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 48,494.8 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/33, А/103, А/171 дугаар тушаалаар үнэ төлбөргүй 298,363.1 мянган төгрөгийн хөрөнгө, НӨХГ-ын даргын 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 1/2160 дугаар тогтоолоор 1,581,829.3 мянган төгрөгийн үлдэх өртөггүй үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж үнийг шинэчлэн тогтоосон 474,548.8 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, НӨХГ-ын даргын 2025 оны А/673 дугаар тушаалаар 484,356.0 мянган төгрөгийн хөрөнгийг актлаж, 1,401,177.3 мянган төгрөгийн элэгдэл байгуулж, хасагдсан үндсэн хөрөнгийн элэгдэл 5,024,218.7 мянган төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 2,308.4 мянган төгрөг болж өсөхөд аудит баталгаажуулалтын төлбөрийг бүртгэсэн нь нөлөөлсөн байна.

Программ хангамжийн талаарх судалгааны үр дүн:

Тус төв нь 7,920.0 мянган төгрөгийн Санхүүгийн /Unicus/, 1,200.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн, 75.0 мянган төгрөгийн хүний нөөцийн, 17,820.0 мянган төгрөгийн нөөцийн агуулахын, 28,200.0 мянган төгрөгийн E-Health, нийт 55,215.0 мянган төгрөгийн программ хангамж ашигладаг бөгөөд жилийн хураамжийн дүн 4,752.0 мянган төгрөг байна. Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-тай нийцүүлэн программд шинэчлэлт хийсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Зооноз өвчин судлалын үндэсний төв нь 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 5,245,257.7 мянган төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлогоос 24,631.7 мянган төгрөг бүрдүүлэхээр, нийт зарлагыг 5,269,889.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 32,904.0 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 4,112.9 мянган төгрөгөөр, нийт 37,016.9 мянган төгрөгөөр зардлыг бууруулж, 5,232,872.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Энэ нь төсвийн төслийг боловсруулахдаа бодит тоо мэдээг үндэслэн судалгаа, тооцоолол хийгээгүй, үндэслэлтэй төлөвлөөгүйгээс шалтгаалсан байна.

Тайлант онд батлагдсан төсвийг 167,603.3 мянган төгрөгөөр бууруулж, 5,065,269.2 мянган төгрөгөөр тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 5,040,637.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 24,631.7 мянган төгрөгийг үндсэн бус үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 4,883,820.2 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үндсэн бус үйл ажиллагааны орлого 35,159.7 мянган төгрөгийг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,883,820.2 мянган төгрөг буюу 96.4 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 170,393.6 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлэг 11,055.4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	5,065,269.2	4,883,820.2	181,449.0	96.4
1.1	Үндсэн үйл ажиллагааны зардал	4,947,847.8	4,777,454.2	170,393.6	96.6
1.2	Бусад урсгал шилжүүлэг	117,421.4	106,366.0	11,055.4	90.6

1. Байгууллагуудын орон тооны цомхотголын талаар

Тус төв нь бүтэц орон тоог 100 ажилтантай байхаар баталж 3,555,764.9 мянган төгрөгийн цалингийн зардал төлөвлөсөн бөгөөд Засгийн газрын чиглэлийн дагуу 9.0 хувиар бууруулж 91 ажилтанаар бүтэц орон тоог баталж, 126,606.9 мянган төгрөгийн цалингийн зардлыг хэмнэсэн байна.

2. Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын талаар:

Захирлын 2025 оны 1 дүгээр сарын 08-ны өдрийн А/01 дугаар тушаалаар унаа, хоолны зардлыг 1 өдрийн 15.0 мянган төгрөгөөр баталж, тайлант онд 369,381.4 мянган төгрөгөөр баталсан ба гүйцэтгэлээр 289,140.7 мянган төгрөгийн унаа, хоолны зардалд зарцуулсан байна.

3. Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний судалгааны үр дүн:

Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний зардалд 1,972.2 мянган төгрөгийн төсөв баталсан ба гүйцэтгэлээр Химийн бодистой ажиллах аюулгүй ажиллагаа, Лабораторийн чанарын хяналт хийх, Галт зэвсэг ашиглах эрхийн сургалтуудад, нийт 1,972.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Тайлант онд гадаад томилолт, арга хэмжээний зардал, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, төлбөрийн зардал, төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал тус тус гараагүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив 1,290,629.0 мянган төгрөг, Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл 45,948.1 мянган төгрөг, Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 35,647.1 мянган төгрөг, нийт 1,372,224.2 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, урсгал зардалд 1,371,871.2 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 353.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.3.1 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төв нь нэмэлт санхүүжилтийн дансанд хандив тусламжаар 15 төсөл, арга хэмжээнд нийт 1,275,607.2 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож 15 төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт /мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц /хувь/	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	АНУ Флоридагийн их сургууль, Монгол орны хачигаар дамжих халдварын үүсгэгчийн тархалтыг тогтоох судалгааны ажил	2025.03.01-2025.08.30	Монгол орны түгээмэл тархсан бэлчээрийн хачиганд хачгаар дамжих зарим халдварын молекул биологийн шинжилгээ хийх.	100.0	43,416.3	43,416.3
2	ДЭМБ, Монгол орны уйланхайт бэтэг өвчний эмнэлзүйн удирдамжийг сайжруулах болон нэг эрүүл мэнд зарчимд уялдуулах нь	2025.01.01-2025.06.30	ДЭМБ-ын зөвлөж буй зааврын (WHO-IWGE) хэрэгжилт, бодит хэрэглээний талаар эмч мэргэжилтнүүдийн санал бодлыг тусгасан үнэлгээ гарна.	100.0	2,531.8	2,531.8
3	ДЭМБ, МУ-д тохиолдож болзошгүй нийгмийн эрүүл мэндийн ноцтой бэлэн байдал, хариу арга	2025.04.01-2025.08.31	Монгол улсад тохиолдож болзошгүй нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээний чадавхын үнэлгээ хийх, бусад холбогдох эрх зүйн баримт	100.0	152,709.0	152,709.0

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	хэмжээний чадавхийн үнэлгээ хийх, холбогдох баримт бичиг боловсруулах		бичигтэй уялдуулан нэгдсэн стратеги төлөвлөгөө, эрсдэлийн зураглал зэрэг холбогдох баримт бичгийн боловсруулна.			
4	ДЭМБ, Орон нутгийн онцлогт тохирсон нутагшмал зоонозын тэргүүлэх өвчний жагсаалтыг гаргах, тандалт, оношилгооны тулгамдсан асуудлыг тодорхойлох	2025.04.01-2025.08.30	Орон нутаг бүрийн байгалийн голомтын онцлогт тохирсон нутагшмал зоонозын тэргүүлэх өвчний жагсаалт, эдгээрийг оношлоход шаардлагатай оношлуур, тоног төхөөрөмж, чанар биоаюулгүй ажиллагаа, био хамгааллын чиглэлээр хийх ажлын хэрэгцээ, шаардлага тодорхойлно.	100.0	52,196.0	52,196.0
5	ДЭМБ, Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшгийн үеийн хариу арга хэмжээ дадлага сургуулилалт хийх	2025.05.01-2025.07.31	Эмнэлгийн яаралтай тусламжийн баг хүч хэрэгслийг нэмэлтээр шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалтыг гаргаж дадлага сургуулилтаас гарсан үр дүн, дүгнэлтийг харьяа эрүүл мэндийн байгууллагуудад зөвлөмжөөр хүргүүлсэн байна.	100.0	92,787.1	92,787.1
6	ДЭМБ, Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн шуурхай удирдлагын төвийн үйл ажиллагааны стандарт журам болон виртуал сургуулилалтын хөтөлбөр боловсруулах	2025.04.01-2025.08.30	Батлагдсан нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн шуурхай удирдлагын төвийн үйл ажиллагааны стандарт журам болон боловсруулсан виртуал сургалтыг хөтөлбөр боловсруулан батлуулж, үйл ажиллагаандаа ашиглаж эхэлсэн байна.	100.0	37,350.0	37,350.0
7	НҮБХС, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн харьяа нийслэл, аймгийн ЗӨСТөвүүдэд чанар, тусламж үйлчилгээ, үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт хийх	2025.04.01-2025.12.31	Нийслэл, аймгийн ЗӨСТөвүүдэд чанар, тусламж үйлчилгээ, үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт хийх. Үнэлгээний дүнд стандартыг шаардлагын дагуу сайжруулах хэрэгцээ шаардлагыг гаргаж, шийдвэр гаргагч нарт танилцуулна. Батлагдсан удирдамжийн дагуу хийсэн дэмжлэгт хяналтын шалгуур хуудаснуудыг нэгтгэх, нэгдсэн зөвлөмж бичиж эргэн мэдээлэх, тусламж, үйлчилгээг сайжруулах арга хэмжээг шийдвэрлүүлэх.	100.0	70,575.8	70,575.8
8	НҮБХС, Зоонозын өвчин судлалын үндэсний төвд ISO 9001:2015 стандартын сургалт, үнэлгээ хийх	2025.06.01-2025.12.31	Олон улсын чанарын менежментийн тогтолцоонд ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэхийн өмнөх гарааны дүн шинжилгээ хийж, түүний дагуу стандартын шаардлагад нийцүүлэх нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх талаар шийдвэр гаргагч нарт танилцуулах.	100.0	144,000.0	144,000.0
9	НҮБХС, Зоонозын өвчин судлалын үндэсний төвд MNS ISO/IEC 17025:2018 сорилтын болон шалгалт	2025.06.01-2025.12.32	Зоонозын сүлжээ лаборатори MNS ISO/IEC 17025:2018 стандарт, итгэмжлэлийн тогтолцооны эрхзүйн орчны талаар мэдлэг эзэмшсэн хүний нөөц бүрдэнэ. Зоонозын сүлжээ	100.0	130,114.0	130,114.0

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	тохируулгын лабораторийн чадавхид тавигдах шаардлага, холбогдох баримт бичиг боловсруулах		лабораторийн чанарын удирдлагын тогтолцоонд баримтлах шинжилгээний стандарт ажлын заавар, анхан шатны бүртгэл маягыг боловсруулах хэрэгжүүлсэн байна.			
10	ДЭМБ, Yersinia-15 Олон улсын симпиозумыг зохион байгуулах	2025.06.01-2025.10.31	Орон нутгийн болон үндэсний төвийн мэргэжилтэнүүдэд тарваган тахал болон зоонозын бусад халдварын чиглэлээр сүүлийн үеийн шинэлэг мэдээллээр хангагдаж, судалгааны арга зүйн хувьд чадавхжсан байна.	100.0	112,641.9	112,641.9
11	ДЭМБ, ЭМЯ, ХХААЯ, БОАЖЯ-ны хамтарсан тушаалаар батлуулсан дунд хугацааны нэг эрүүл мэнд төлөвлөгөө боловсруулах	2025.08.01-2025.12.31	ЭМЯ, мал эмнэлэг, байгаль орчны асуудал хариуцсан ЗГ-ын гишүүдийн хамтарсан "Нэг эрүүл мэнд" зөвлөлийн тушаал, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллана.	76.3	196,704.0	196,704.0
12	НҮБХС, Зоонозын өвчний тандалтын системийг сайжруулахад зайнаас тандан судлалын технологи ашиглах арга зүйд суралцах нь сургалт үнэлгээ хийх	2025.08.01-2025.12.31	Зайнаас тандан судлалын технологи ашиглах арга зүйг онол, практик хослуулан хиймэл дагуулын мэдээ ашиглалт, түүнд боловсруулалт хийх, сэдэвчилсэн зураг боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн бий болгон, сургалтад оролцогчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлнэ.	100.0	125,974.0	125,965.1
13	АНУ Флоридагийн их сургууль, Монгол оронд тархсан зарим зүйлийн иксод хачгийн тархалт болон хачгаар дамжих халдварын үүсгэгчдийн хэв шинж, тархалтыг судлах	2025.08.01-2025.12.31	Монгол орны түгээмэл тархсан бэлчээрийн хачиганд хачгаар дамжих зарим халдварын молекул биологийн шинжилгээ хийх. шинжилгээний зарим үр дүнг нэгтгэж олон улсын эрдэм шинжилгээний хурал, ном товхимолд нийтэлж бусад судлаач, эрдэмтдийн хүртээл болгох.	100.0	44,922.4	44,585.4
14	ДЭМБ, Yersinia-15 Олон улсын симпиозумыг зохион байгуулах	2025.06.01-2025.10.31	Тарваган тахал болон зоонозын бусад халдваруудыг үндэсний болон бүс нутгийн хэмжээнд хянахад олон улсын хэмжээнд нэг эрүүл мэнд үзэл баримтлалын хүрээнд хамтын ажиллагааг өргөжүүлэх, хамтран ажиллах байгууллагуудын үйл ажиллагааны чиглэл тодорхойлогдсон байна.	100.0	31,001.4	31,001.4
15	ДЭМБ, Хөвсгөл аймагт бүртгэгдсэн тарваган тахлын дэгдэлтийн хариу арга хэмжээний дараах үнэлгээ хийх	2025.09.01-2025.12.31	Хөвсгөл аймгийн Мөрөн суманд бүртгэгдсэн тарваган тахлын дэгдэлтийн хариу арга хэмжээний дараах үнэлгээ хийж, цаашид хэрэгжүүлэх урт, дунд, богино хугацааны зөвлөмж боловсруулан хэрэгжүүлэх.	100.0	38,683.6	38,683.6
НИЙТ					1,275,607.2	1,275,261.3

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Зооноз өвчин судлалын үндэсний төв нь тайлант онд худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөөг нээлттэй тендер шалгаруулалтаар 410,000.0 мянган төгрөгийн, харьцуулалтын аргаар 45,000.0 мянган төгрөгийн, шууд гэрээ байгуулах аргаар 85,158.1 мянган төгрөгийн худалдан авалт хийхээр 25 багц арга хэмжээнд 540,158.1 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөсөн.

Гүйцэтгэлээр нээлттэй тендер шалгаруулалтын аргаар оношлуур, урвалж, химийн бодис, тэжээлт орчин худалдан авах 409,951.0 мянган төгрөг, харьцуулалтын аргаар анхан шатны маягт худалдан авах 44,955.0 мянган төгрөг, шууд гэрээ байгуулах аргаар 86,078.2 мянган төгрөг, нийт 540,984.2 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах талаар хүний нөөцийн бүртгэл, худалдан авах ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Их Наяд Аудит ХХК-ийн ахлах аудитор Х.Ариунтуяа, аудитор М.Мөнхзул нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал Х.Ариунзул, Санхүүгийн аудитын газрын аудитор Б.Отгонцэцэг, аудитын менежер В.Эрдэнэцогт, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Их Наяд Аудит” ХХК-нд 2026 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 1а/68 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 8,246,183.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 82,461.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор батлагдсан улсын төсвийн 96.4 хувийг зарцуулж, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 9,533.8 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 20,879.1 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 49.6 мянган төгрөгөөр, томилот зочны зардлыг 11,203.9 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 312.9 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 152.1 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийн зардлыг 1,136.7 мянган төгрөгөөр буюу нийт 181,449.0 мянган төгрөгийг дутуу зарцуулж улсын төсөвт төвлөрүүлжээ.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой төлөвлөсөн горим сорилыг гүйцэтгэхэд тус хуулийг зөрчсөн асуудал аудитын явцад илрээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 749,031.3 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 1 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 20 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант онд шилэн дансны цахим системд 10,471,466.0 мянган төгрөгийн 212 мэдээллийг ил тод байршуулахаас 749,031.3 мянган төгрөгийн дүн бүхий 49 мэдээллийг дутуу мэдээллэсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”, 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх” 4.1.2-т “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4.4-д “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудаст мэдээллийг иж бүрэн мэдээллээгүй зөрчлийг таслан зогсоох, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Санхүүгийн тайлан дахь засгийн газрын хувь оролцооны дүн нь 2,698,660.7 мянган төгрөг буюу байгууллагын гэрчилгээн дээрх дүнгээс 1,200,720.7 мянган төгрөгөөр илүү тусгагдсан буюу өөрчлөлтийг улсын бүртгэлд хийлгээгүй байна. Энэ нь Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4-д “Гүйцэтгэх удирдлага нь энэ хуулийн 31.3-т заасан нөхцөл байдал үүссэн тухай болон түүнийг хэрхэн шийдвэрлэсэн тухай мэдээллийг шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор тухайн компанийн зээлдүүлэгчид мэдээлэх үүрэгтэй”, 16 дугаар зүйлийн 16.2.2-т “компанийн зарласан болон гаргасан хувьцааны тоо, тэдгээрийн төрөл, нэрлэсэн үнэ, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ”, 30 дугаар зүйлийн 30.5-д “Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг компанийн дүрэмд тусгасан байна” гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагатай холбоотой өөрчлөлтийг улсын бүртгэлд хийлгэх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, зардал, орлогын данстын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулсан. Завсрын аудитаар 130,758.6 мянган төгрөгийн 2 алдааг залруулсан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 33,985.1 мянган төгрөгийн 7 зөвлөмж, 4,917,796.6 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 7,491.4 мянган төгрөгийн 1 хариуцлага тооцох албан шаардлага өгснөөс 6 зөвлөмж, 3 албан шаардлага, 1 хариуцлага тооцох албан шаардлага бүрэн хэрэгжүүлж, 96.6 хувьтай байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Хариуцлага тооцох албан шаардлага	1	7,491.4	1	7,491.4	100.0
Албан шаардлага	3	4,917,796.6	3	4,917,796.6	100.0
Зөвлөмж	7	33,985.1	6	31,849.3	90.0
Нийт дүн	11	4,959,273.1	10	4,957,137.3	96.6

Өмнөх аудитын ажилтан, албан хаагчдад ур чадварын нэмэгдэл хөлс олгохдоо төвийн захирлын баталсан журмыг мөрдөөгүй, үнэлгээний хуудас, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэр гараагүй байхад ажилтануудад ур чадварын нэмэгдэл хөлс олгосон зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Өмнөх аудитаар өгсөн 1 зөвлөмжийг давтан гаргасан тул албан шаардлага хүргүүлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журмын хэрэгжилт, санхүүгийн программд шинэчлэлийг бүрэн хийж төсвийн гүйцэтгэлийн болон тодруулга үнэн зөв гаргаж байгаа эсэхийг судлах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 156,595.9 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрснээс аудитын явцад 156,595.9 мянган төгрөгийн 1 алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

- Өр төлбөрийн тодруулга үлдэгдэлгүй байхад журналд тусгахдаа харилцагчийг буруу сонгож 156,595.9 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалттай тус тус нийцээгүй байна.

Аудитаар нийт 148,219.3 мянган төгрөгийн 7 зөрчил² илэрснээс, 5,863.8 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 137,964.6 мянган төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлж, 4,390.9 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 148,219.3 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 65,757.5 мянган төгрөгөөр давсан тул Хязгаарлалттай санал дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Тус төвийн нэр бүхий 39 ажилтан, албан тушаалтанд орон нутагт албан томилолтоор ажилласан хугацааны нөхөн олговорт төлбөртэй давхардуулан 5,340.5 мянган төгрөгийн хоол, унааны хөнгөлөлт олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор баталсан Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журмын 2.2-т Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараахь зардлаас бүрдэнэ: "2.2.1-д унааны зардал, 2.2.2-т байрны зардал, 2.2.3-т хоолны зардал" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Унаа, хоолны хөнгөлөлтийг давхардуулан олгосон буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж, улсын төсөвт төвлөрүүлнэ гэж төлбөрийн акт тогтоов.

5.1.2 Төвийн эдийн засагч албан тушаалтай 1 ажилтанд цалинтай чөлөө олгохдоо 4 дүгээр сард хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 8 хоног, 6 дугаар сард Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ажилтны өргөдөл болон тасгийн даргын зөвшөөрөлгүйгээр 10 хоног, нийт 18 хоногийн 523.3 мянган төгрөгийн цалин бодож олгосон байна. Энэ нь Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2023 оны 3 дугаар сарын 29-ний А/18-ны тушаалаар баталсан Хөдөлмөрийн дотоод журмын 6 дугаар зүйлийн 6.2.1.2-т "Ажилтны гаргасан өргөдлийн дагуу алба, тасгийн даргын цохолтыг үндэслэн Төвийн захирлын тушаалаар 3 ба түүнээс дээш хоног", 16 дугаар зүйлийн 16.5.1 "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөдөлмөрийн дотоод журамд заасан шалгуур үндэслэл хангахгүй, хүндэтгэн үзэх шалтгаангүй, бүрдэл дутуу баримтаар цалинтай чөлөө бодож олгосон зөрчлийг улсын төсөвт төвлөрүүлнэ гэж төлбөрийн акт тогтоов.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.2 Албан шаардлага

5.2.1 Төвийн үндсэн ажилтан жолооч Д.Болдбаатарт тайлант онд цагийн бүртгэл болон жолоочийн замын хуудсаар бүрэн баталгаажаагүй, нийт 31,449.9 мянган төгрөгийн цалин олгосон бөгөөд Эрүүл мэндийн яаманд гэрээтээр давхар ажиллаж сар бүр 1,500.0 мянган төгрөгийн цалинг авсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, Хөдөлмөрийн тухай хуулийн 84 дүгээр зүйл 84.1-д “Долоо хоногийн ердийн ажлын цаг 40-өөс илүүгүй байна” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тус төвийн үндсэн ажилтан бусад төсвийн байгууллагад гэрээтээр давхар ажил эрхэлсэн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5.2.2 Түлш, шатах тослох материалын хэмжих нэгж, нэг бүрийн үнэгүйгээр нийт мөнгөн дүнгээр орлого авч зарлагддаг, замын хуудсыг үндэслэн жолоочийн тооцоо бодоогүй, зэрэг нийт 81,493.1 мянган төгрөгийн шатахууны зарцуулалтанд бүртгэлээр тавих хяналт хангалтгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай 5 дугаар зүйлийн 5.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.5-д “хэмжигдэхүйц байх”, 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Түлш, шатах тослох материалыг нийт дүнгээр зарлагдсан, анхан шатны бүрдэл дутуу баримтаар зардалд бүртгэсэн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5.2.3 Ажилтан, албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгохдоо төвийн захирлын баталсан журмыг мөрдөөгүй, үнэлгээний хуудас, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэр гараагүй байхад нэр бүхий 15 ажилтанд 12,706.6 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл хөлс олгож, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2023 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн А/38 дугаар тушаалаар баталсан “Ур чадварын нэмэгдэл олгох журам”-ыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажилтан, албан хаагчдад ур чадварын нэмэгдэл хөлс олгохдоо төвийн захирлын баталсан журмыг мөрдөөгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5.2.4 Төв нь автомашины техникийн үзлэгийн карт хөтлөөгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу 12,315.1 мянган төгрөгийн засварын зардал гаргасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Автомашины засварын материалыг анхан шатны бүрдэл дутуу баримтаар зардалд бүртгэсэн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус төвд бүртгэлтэй 15 авто тээврийн хэрэгсэлтэй холбоотой 2025 оны 4,390.9 мянган төгрөгийн АТӨЯХАТ төлөгдөөгүй байна. Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйл 7.1-т “Хувь хүн нь авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн жилийн албан татварыг жилд нэг удаа тухайн жилийн 6 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө харьяалах татварын албанд төлнө. Хэрэв 6 дугаар сарын 1-нээс хойш авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийг импортоор оруулж ирсэн бол харьяалах татварын албанд тухайн жилдээ багтаан үлдсэн хугацаанд ногдох татварыг төлнө”, 7.2-т “Аж ахуйн нэгж, байгууллага автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн жилийн албан татварыг тэнцүү хэмжээгээр улирал бүрийн сүүлчийн сарын 25-ны дотор багтаан төсөвт төлнө” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Авто тээврийн хэрэгсэлтэй холбоотой татварын өр төлбөрийг барагдуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Өр төлбөрийн тодруулга үлдэгдэлгүй байхад журналд тусгахдаа харилцагчийг буруу сонгож илүү дутуу илэрхийлсэн байна.	1	156,595.9			1	156,595.9	1	156,595.9				
	Дүн	1	156,595.9			1	156,595.9	1	156,595.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал	
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Тоо	Дүн
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Төвийн эдийн засагч албан тушаалтай 1 ажилтанд цалинтай чөлөө олгохдоо 4 дүгээр сард хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 8 хоног, 6 дугаар сард Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ажилтны өргөдөл болон тасгийн даргын зөвшөөрөлгүйгээр 10 хоног, нийт 18 хоногийн цалинтай чөлөө олгосон байна	1	523.3	1	523.3								
2	Албан томилолтоор ажилласан нэр бүхий 39 албан хаагчдад унаа, хоолны хөнгөлөлтийг	1	5,340.5	1	5,340.5								

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	давхардуулан илүү олгосон байна												
3	Тус төвийн үндсэн ажилтан жолооч Д.Болдбаатар нь 2025 онд ажилласан цагийн бүртгэлгүй үндсэн цалингаа сар бүр бүтэн авч, нийт 31,449.9 мянган төгрөгийн цалинг төсвөөс олгосон байна. Гэтэл тус жолооч нь тайлант онд Эрүүл мэндийн яаманд гэрээтээр давхар ажиллаж сар бүр 1,500.0 мянган төгрөгийн цалинг авсан байна. Тус төвд үндсэн ажлаа бүрэн хийж байсан эсэх нь цагийн бүртгэл болон жолоочийн замын хуудсаар нотлогдохгүй байна	1	31,449.9			1	31,449.9						
4	Ажилтан, албан хаагчдад ур чадварын нэмэгдэл хөлс олгохдоо төвийн захирлын баталсан журмыг мөрдөөгүй, үнэлгээний хуудас, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэр гараагүй байхад нэр бүхий 15 ажилтанд ур чадварын нэмэгдэл хөлс олгож өмнөх аудитын зөвлөмийг хэрэгжүүлээгүй байна.	1	12,706.6			1	12,706.6						
5	Түлш, шатах тослох материалын хэмжих нэгж, нэг бүрийн үнэгүйгээр нийт мөнгөн дүнгээр орлого авч зарлагддаг, замын хуудсыг үндэслэн жолоочийн тооцоо бодоогүй, шатахууны зарцуулалтанд бүртгэлээр тавих хяналт хангалтгүй байна.	1	81,493.1			1	81,493.1						
6	Автомашинь техникийн үзлэгийн карт хөтлөөгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу,	1	12,315.1			1	12,315.1						

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	засварын зардалд 12,315.1 мянган төгрөг төлсөн байна.											
7	Тус төвд бүртгэлтэй 15 автомашин холбоотой 2025 оны 4,390.9 мянган төгрөгийн АТӨЯХАТ төлөгдөөгүй байна	1	4,390.9					1	4,390.9			
	Дүн	7	148,219.3	2	5,863.8	4	137,964.6	1	4,390.9			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
	Тоо	Дүн	Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Шилэн дансанд Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний 749,031.3 мянган төгрөгийн зарлагын 49 мэдээллийг дутуу байршуулсан байна	1	749,031.3	1	749,031.3		
Дүн	1	749,031.3	1	749,031.3		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Санхүүгийн тайлан дах засгийн газрын хувь оролцооны дүн нь 2,698,660.7 мянган төгрөг буюу байгууллагын гэрчилгээн дээрх дүнгээс 1,200,720.7 мянган төгрөгөөр илүү тусгагдсан буюу өөрчлөлтийг улсын бүртгэлд хийлгээгүй байна	1	-			1	-
Дүн	1	-			1	-
Нийт дүн	2	749,031.3	1	749,031.3	1	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 42/АД150185

Улаанбаатар хот

САГ - 2026/97/НА - СТА - ТЦЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Нэр бүхий хавсралтад дурдсан 39 ажилтан, албан тушаалтанд орон нутагт албан томилолтоор ажилласан хугацааны нөхөх төлбөртэй давхардуулан 5,340,532.50 /таван сая гурван зуун дөчин мянга таван зуун гучин хоёр төгрөг тавин мөнгө/ төгрөгийн хоол, унааны хөнгөлөлт олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйл 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор баталсан Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журмын 2.2-т Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараах зардлаас бүрдэнэ" 2.2.1-д унааны зардал, 2.2.2-т байрны зардал, 2.2.3-т хоолны зардал" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь**:

1. Унаа, хоолны хөнгөлөлтийг давхардуулан олгосон 5,340,532.50 /таван сая гурван зуун дөчин мянга таван зуун гучин хоёр төгрөг тавин мөнгө/ төгрөгийг Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн ерөнхий нягтлан бодогч Д.Болормаагаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн Захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Амгаланбаяр)-т хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ НАЯД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Х.АРИУНЗУЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 43/A0150185

Улаанбаатар хот

САГ - 2026/97/НА - СТА - ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн эдийн засагч албан тушаалтай 1 ажилтанд цалинтай чөлөө олгохдоо 4 дүгээр сард хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 8 хоног, 6 дугаар сард Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ажилтны өргөдөл болон тасгийн даргын зөвшөөрөлгүйгээр 10 хоног, нийт 18 хоногийн 523,278.78 /таван зуун хорин гурван мянга хоёр зуун далан найман төгрөг далан найман мөнгө/ төгрөгийн цалин бодож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2023 оны 3 дугаар сарын 29-ний А/18-ны тушаалаар баталсан Хөдөлмөрийн дотоод журмын 6 дугаар зүйлийн 6.2.1.2-т "Ажилтны гаргасан өргөдлийн дагуу алба, тасгийн даргын цохолтыг үндэслэн Төвийн захирлын тушаалаар 3 ба түүнээс дээш хоног" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хөдөлмөрийн дотоод журамд заасан шалгуур үндэслэл хангахгүй, хүндэтгэн үзэх шалтгаангүй, бүрдэл дутуу баримтаар цалинтай чөлөө бодож олгосон 523,278.78 /таван зуун хорин гурван мянга хоёр зуун далан найман төгрөг далан найман мөнгө/ төгрөгийг ерөнхий нягтлан бодогч Д.Болормаагаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн Захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Амгаланбаяр)-д хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ НАЯД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Х.АРИУНЗУЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 247/АД150185

Улаанбаатар хот

САГ-2026/97/НА-СТА-ТЦЗ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хавсралтад дурдсан албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгохдоо төвийн захирлын баталсан журмыг мөрдөөгүй, үнэлгээний хуудас, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэр гараагүй байхад нэр бүхий 15 ажилтанд 12,706,550.00 *Арван хоёр сая долоон зуун зургаан мянга таван зуун тавин* төгрөгийн ур чадварын нэмэгдэл хөлс олгож, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2023 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн А/38 дугаар тушаалаар баталсан "Ур чадварын нэмэгдэл олгох журам"-ыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ажилтан, албан хаагчдад ур чадварын нэмэгдэл хөлс олгохдоо төвийн захирлын баталсан журмыг мөрдөөгүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн Захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Амгаланбаяр), ерөнхий нягтлан бодогч (Д.Болормаа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ НАЯД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Х.АРИУНЗУЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 248/А0150185

Улаанбаатар хот

САГ - 2026/97/НА - СТА - ТЦЗ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд.

Түлш, шатах тослох материалын хэмжих нэгж, нэг бүрийн үнэгүйгээр нийт мөнгөн дүнгээр орлого авч зарлагддаг, замын хуудсыг үндэслэн жолоочийн тооцоо бодоогүй, зэрэг нийт 81,493,084.00 *Инаян нэгэн сая дөрвөн зуун ерин гурван мянга наян дөрвөн* төгрөгийн шатахууны зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт хангалтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай 5 дугаар зүйлийн 5.1.5-д хэмжигдэхүйц байх", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Түлш, шатах тослох материалыг нийт дүнгээр зарлагдсан, анхан шатны бүрдэл дутуу баримтаар зардалд бүртгэсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн Захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Амгаланбаяр), ерөнхий нягтлан бодогч (Д.Болормаа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ НАЯД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Х.АРИУНЗУЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 249/АД150185

Улаанбаатар хот

САГ-2026/97/НА -СТА -ТШЗ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд Шилэн дансны цахим системд Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний 749,031,330.00 /долоон зуун дөчин есөн сая гучин нэгэн мянга гурван зуун гуч/ төгрөгийн зарлагын 49 мэдээллийг дутуу байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална", 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх" 4.1.2 "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.4-д "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим системд мэдээлэл дутуу оруулсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн Захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Амгаланбаяр), ерөнхий нягтлан бодогч (Д.Болормаа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ НАЯД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Х.АРИУНЗУЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 250 /А0150185

Улаанбаатар хот

САГ-2026/97/НА -СТА-ТШЗ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус төвийн үндсэн ажилтан жолооч Д.Болдбаатарт тайлант онд цагийн бүртгэл болон жолоочийн замын хуудсаар бүрэн баталгаажуагүй, нийт 31,449,918.00 /гучин нэгэн сая дөрвөн зуун дөчин есөн мянга есөн зуун арван найман/ төгрөгийн цалин олгосон бөгөөд Эрүүл мэндийн яаманд гэрээтээр давхар ажиллаж сар бүр 1,500,000.00 /нэг сая таван зуун мянга/ төгрөгийн цалинг авсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Хөдөлмөрийн тухай хуулийн 84 дүгээр зүйл 84.1-д "Долоо хоногийн ердийн ажлын цаг 40-өөс илүүгүй байна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тус төвийн үндсэн ажилтан бусад төсвийн байгууллагад гэрээтээр давхар ажил эрхэлсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн Захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Амгаланбаяр), ерөнхий нягтлан бодогч (Д.Болормаа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ НАЯД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Х.АРИУНЗУЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230



Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-41.Docx

1526180670



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 251/А0150185

Улаанбаатар хот

САГ-2026/97/НА-СТА-ТШЗ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус төв нь автомашины техникийн үзлэгийн карт хөтлөөгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу 12,315,100.00 *Арван хоёр сая гурван зуун арван таван мянга нэг зуун* төгрөгийн засварын зардал гаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Автомашины засварын материалыг анхан шатны бүрдэл дутуу баримтаар зардалд бүртгэсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн Захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Амгаланбаяр), ерөнхий нягтлан бодогч (Д.Болормаа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ НАЯД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Х.АРИУНЗУЛ